



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 624

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө худалдах, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэрийн, нийт 498,461.54 (дөрвөн зуун ерэн найман мянга дөрвөн зуун жаран нэгэн ам.доллар тавин дөрвөн цент) ам.долларын балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг, худалдаж, данснаас хасахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар тогтоосугай.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд, Ерөнхий консул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгө худалдсанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

  
Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 4 дугаар сарын 2 ны өдрийн  
 64 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСААС ГАДААД УЛСАД СУУГАА ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДЫН  
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуриутлагдсан элэгдэл (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байршил (Элчин сайдын яам, ЕКГ)
1	Toyota Hiace маркийн микроавтобус, СД 047-101 дугаартай, Арлын дугаар -JT121JK2200043005	2008/2008	216671	31,397.86	1,000.00	Будапешт ЭСЯ
2	Мерседес бенз S 350 маркийн суудлын автомашин, С 24-006 дугаартай, Арлын дугаар - WDD2221321A135698	2014/2014	90000	86,242.48	2,000.00	Брюссель ЭСЯ
3	Хьюндай Н1 маркийн микроавтобус, D 24-006 дугаартай, Арлын дугаар - HWH81RBEU633	2014/2014	206126	29,387.79	1,000.00	Бишкек ЭСЯ
4	Волькасвеган Каравел VW маркийн микроавтобус, 34CC-2542 дугаартай, Арлын дугаар -WVZZZ7HZFH14157	2015/2015	220143	28,400.00	1,000.00	Истанбул ЕКГ
5	Тоёота Камри маркийн суудлын автомашин, CD-3911 дугаартай, Арлын дугаар -MR053BK4107054699	2010/2010	175751	29,666.67	1,000.00	Сингапур ЭСЯ
6	Тоёота фортунер маркийн суудлын автомашин, CD-005 дугаартай, Арлын дугаар -MBJ11JVS105036547	2014/2014	118649	46,000.00	1,000.00	Дели ЭСЯ

№	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байршил (Элчин сайдын яам, ЕКГ)
7	Хьюндай Н-2.4 маркийн микроавтобус, CD-002 дугаартай, Арлын дугаар - MNXWF31RMFI204083	2015/2015	78299	22,330.00	1,000.00	Дели ЭСЯ
8	Toyota Veilfire маркийн микроавтобус /суудлын/, UA26-52 дугаартай, арлын дугаар JIMCV091904140485	2016/2016	133234	50,790.40	1,000.00	Хонгконг дахь ЕКГ
9	BMW-730 маркийн автомашин /суудлын/, CD-002LL дугаартай, арлын дугаар WBAУС410100DZ7397	2011/2012	150000	84,793.36	2,000.00	Ром дахь ЭСЯ
10	BMW 750 xDrive, маркийн суудлын автомашин, CD-188 дугаартай, арлын дугаар WBAУВ61060С997788	2013/2013	250820	89,452.98	2,000.00	Женев БТГ/ЭСЯ
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>498,461.54</b> (дөрвөн зуун ерэн найман мянга дөрвөн зуун жаран нэгэн доллар тавин дөрвөн цент)	<b>13,000.00</b> (арван гурван мянган доллар)	